



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 09 сарын 26 өдөр

Дугаар А/422

Мандалговь

Эзэмшил газрыг хуваах тухай

Монгол улсын Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Сайнцагаан сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэрт (Мандал сургуулийн урд талд) байршилтай "ЭОЖИН" ХХК (РД:3430553)-ний үйлчилгээтэй түрээсийн орон сууцны зориулалттай 2900м.кв (0.29га) газрыг 1700 м.кв (0.17га), 1200 м.кв (0.12га)-аар тус тусд нэгж талбар болгон хувааж "ЭОЖИН" ХХК-д зориулалтаар нь 13 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

Хоёр. Дээрх аж ахуй нэгжтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Э.Чагнаадорж), мөн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг ГХБХБГазар, Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч (Р.Мөнхтогтох), аймгийн Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат) нарт тус тус үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны 04 дүгээр сарын 04-ны өдрийн А/95 тоот захирамжийн "ЭОЖИН"ХХК-д холбогдох хэсэг мөн газар эзэмших 000308218 тоот гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

408010335

